



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 334

Улаанбаатар хот

Компанийн эзэмшигчдийн өмч дэх
төрийн өмчийн дүн, дүрэмд өөрчлөлт
оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2014-2016 онд хийгдсэн нийт 10,651,725,701,3 /арван тэрбум зургаан зуун тавин нэгэн сая долоон зуун хорин таван мянга долоон зуун нэг төгрөг гучин мөнгө/ төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийн дүнгээр “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн эзэмшигчийн өмч дэх төрийн өмчийн дүнг нэмэгдүүлэхийг зөвшөөрсүгэй.


2. “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 3.1 дэх заалтанд “Компани нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,232,735,087 /Нэг тэрбум хоёр зуун гучин хоёр сая долоон зуун гучин таван мянга наян долоон/ ширхэг хувьцаатай” гэснийг “Компани нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,339,252,344 /Нэг тэрбум гурван зуун гучин есөн сая хоёр зуун тавин хоёр мянга гурван зуун дөчин дөрвөн/ ширхэг хувьцаатай” гэж өөрчилсүгэй.

3. “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн эзэмшигчийн өмч дэх төрийн өмчийн дүнд орсон өөрчлөлтийг холбогдох байгууллагад бүртгүүлэхийг компанийн гүйцэтгэх захирал Д.Бямба-Очирт үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Бодлого, төлөвлөлт удирдлагын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА